



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А1510

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн байгууллагад
Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тусламж,
үйлчилгээнд хэрэглэсэн нэг удаагийн хамгаалах
хувцас, хэрэгслийг устгах түр заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 8.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн байгууллагад Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тусламж, үйлчилгээнд хэрэглэсэн нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслийг устгах түр заавар"-ыг хавсралтаар баталсугай.
2. Түр зааврыг мөрдүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д үүрэг болгосугай.

САЙД  Т.МӨНХСАЙХАН

2020-A-tushaal

141202011

Эрүүл мэндийн сайдын 2020 оны
11. сарын 06 - ны өдрийн 8/510 дугаар
тушаалын хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД КОРОНАВИРУСТ
ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД
ХЭРЭГЛЭСЭН НЭГ УДААГИЙН ХАМГААЛАХ ХУВЦАС,
ХЭРЭГСЛИЙГ УСТГАХ ТҮР ЗААВАР**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, тусгаарлан ажиглах байр, хилийн нэвтрэх цэг зэрэгт хэрэглэсэн нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслийг устгахад энэхүү түр зааврыг мөрдөнө.

1.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хэрэглэгдэх нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгсэлд дараах хэрэгслийг хамруулна. Үүнд: халад, комбинзон, шүүлтүүртэй болон шүүлтүүргүй амны хаалт, малгай, ахуйн, үзлэгийн, мэс заслын бээлий, гутлын гадуурх улавч, нүүрний хаалт, нүдний шил, хормогч, ханцуйвч орно.

1.3. Хамгаалах хувцас, хэрэгслийг ангилан ялгаж цуглуулах, түр хадгалах, зөөх, тээвэрлэх үйл ажиллагаанд Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаар тушаалаар батлагдсан зааврыг мөрдөж ажиллана.

Хоёр. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хэрэглэгдэх нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслийг устгах

2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед ашигласан энэ тушаалын 1.2-т заасан хамгаалах хувцас, хэрэгслийг “Биоаюултай” таних тэмдэг бүхий шар өнгийн уутанд цуглуулж, эмнэлгийн тусгай хог хаягдлын түр хадгалах цэгт төвлөрүүлнэ.

2.2. Эмнэлэг дотор болон эмнэлгээс гадна хог хаягдлыг тэргэнцэр эсвэл тагтай, бариултай зориулалтын саваар зөөнө.

2.3. Хамгаалах хувцас, хэрэгслийн хог хаягдлыг хүн амын суурьшлын бүсээс гадна, хог хаягдлын цэгт шатаах зуух ашиглан шатааж устгана.

2.4. Бүрэн шатаж дууссаны дараа үнсийг ландфиллийн аргаар булна. Бүрэн шатсан эсэхийг хог хаягдлын ажилтан хянана.

2.5. Түр хадгалах цэгээс шатаах цэг хүртэл машинаар тээвэрлэнэ. Хог хаягдал тээвэрлэх тусгай машинтай байна.

2.6. Шатааж устгаж байгаа хамгаалах хувцас, хэрэгслийн хог хаягдлыг жинлэн хэмжиж “кг”-аар тооцон халдвартай хог хаягдлыг бүртгэлд оруулна.

2.7. Хамгаалах хувцас, хэрэгслийн хог хаягдалтай харьцаж ажиллаж байгаа ажилтан нэг удаагийн халад эсвэл комбинзон, малгай, шүүлтүүргүй амны хаалт,

нүүрний хаалт, резинэн бээлий ажлын гутал өмсөнө. Шатаах үед галд тэсвэртэй бээлий хэрэглэнэ.

2.8. Хог хаягдал зөөх сав, тэргэнцэр, тээвэрлэх машины цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 537 дугаар тушаалын зургаадугаар хавсралтын 5, 6 дугаар заалтуудыг баримтлан эрүүл мэндийн байгууллагад түгээмэл ашигладаг жавелион 0.03%, гипохлорт натри 1%, ДП-2Т 0,04% уусмалаар арчиж халдваргүйжүүлэнэ. Бодис тус бүрийн халдваргүйжүүлэх үйлчилгээ үзүүлэх хугацааг баримтлана.

2.9. Хамгаалах хувцас хэрэгслийг тээвэрлэсэн, устгасан тэмдэглэлийг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаар тушаалын наймдугаар хавсралт дахь эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг бүртгэх, тээвэрлэх, устгах маягтуудын дагуу хөтөлнө.

2.10. Хамгаалах хувцас, хэрэгслийг устгах үйл ажиллагаанд тухайн байгууллагын халдварын сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж ажиллана.